



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 4/64

Модот

**Уралдаан зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66,1дэх заалт, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,3 дахь заалт, Хэнтий аймгийн Цэнхэрмандал суман дахь "Цэнхэрийн унага" уяачдын салбар холбоо төрийн бус байгууллагын 2026 оны 05 дугаар албан хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1."Цэнхэрийн унага" уяачдын салбар холбоо төрийн бус байгууллагын ирүүлсэн хүсэлтийг үндэслэн хаврын морины бага гурван насны уралдааныг 2026 оны 05 дугаар сарын 05-ний Хужхан багийн нутаг "Хар хошуу"-нд зохион байгуулсугай

2.Морины уралдаан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- |                                     |   |   |
|-------------------------------------|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч Л.Билгүүн      | - | "Цэнхэрийн унага" уяачдын холбооны тэргүүн          |
| Нарийн бичгийн дарга Ж.Амгаа-Гишүүд | - | Уяачдын холбооны тэргүүлэгч                         |
| У.Гантулга                          | - | Хужхан багийн Засаг дарга                           |
| Б.Чулуунцэцэг                       | - | Нугаар багийн Засаг дарга                           |
| Д.Мягмарсүрэн                       | - | Согоот багийн Засаг дарга                           |
| Ц.Номин-Эрдэнэ                      | - | Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан                  |
| Б.Хангай                            | - | Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч               |
| А.Хасбаатар                         | - | Сумын цагдаа, цагдаагийн дэд ахлагч                 |
| О.Буянбаатар                        | - | Уяачдын холбооны тэргүүлэгч                         |
| Б.Баасанлхүмбэ                      | - | Уяачдын холбооны тэргүүлэгч                         |
| Б.Хатансайхан                       | - | "Дэрст хайрхан" МЭҮНэгжийн<br>малын эмч             |
| Ц.Сэвжид                            | - | Эрүүл мандийн төвийн даргыг түр<br>орлон гүйцэтгэгч |
| Х.Өлзийбаяр                         | - | Эрүүл мандийн төвийн жолооч                         |

3.Уралдааныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэргэжил арга зүйгээр хангаж чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Л.Билгүү-д, +Хэв журам болон бусад үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Сумын хэсгийн төлөөлөгч, Б.Хангай-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ



